

Product Data Sheet

Edition 29.07.2010

Identification no:

02 07 03 02 System

Sikaflex-Combiflex® SG System

Sikadur-Combiflex® SG System

Өндөр үзүүлэлттэй залгаас битүүлэх систем

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sikadur Combiflex SG System өндөр үзүүлэлт бүхий залгаас битүүлэх систем нь барилгын өргөтгөл, хөдөлгөөнт зааг, залгаас болон хагарал ан цавыг битүүлэн холбоход хэрэглэгдэнэ. Уг систем нь нэг болон түүнээс олон чиглэгд, өндөр үзүүлэлттэй хувьсах хөдөлгөөнийг хангах ажиллагаас гадна ус чийгнээс найдвартай хамгаалж өгнө.

Sikadur Combiflex SG System нь сайжруулсан уян полиолефин (FPO) усанд тэсвэртэй тууз бөгөөд барьцалдах шинж чанар сайтай бүтээгдэхүүн бөгөөд Sikadur® нэр төрлийн тусгай цавууны хамт, олон төрлийн нөхцөл байдал болон гүйцэтгэлд хэрэглэх боломжтой.

Хэрэглээ:

Барилга, өргөтгөл, залгаасыг холбохоос гадна хагарал гэмтэлд хэрэглэгдэх битүүлэх систем нь дараах бүтээцэд хэрэглэх боломжтой:

- Тунель, дамжуулах хоолойнуудад
- Усан цахилгаан станц
- Цэвэрлэх байгууламж
- Барилгын суурь
- Ус нөөцлөх бүтээц болон ундны ус хадгалах сав
- Ган төмөр болон бетон хоолойнууд
- Усан сан

Битүүлэх зорилгоор:

- Хөдөлгөөн ихтэй залгаасууд
- Ялгаатай суулт өгөх магадлалтай барилгын хэсгүүд
- Хагарал ан цавууд

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Тууз болон цавуу хоорондоо барьцалдах чадвар маш сайн учраас төслийн талбай дээр хэрэглэхдээ нэмэлт идэвхжүүлэгч шаардлагагүй.
- Хурдан, хялбар ажиллагаатай
- Хуурай болон чийгтэй бетонон гадаргууд хэрэглэх боломжтой
- Уян хатан чанар маш сайн
- Температурын өргөн хүрээнд ажиллах чадвар сайтай
- Олон төрлийн материал бүхий гадаргуу дээр ашиглах боломжтой
- Цаг уур болон усны хамгаалалттай



- Хэт ягаан туяаны хамгаалалттай
- Энгийн болон түргэн хугацаанд хатуурч бэхжих цавууны сонголтуудтай
- Хөрсний үндэс нэвчилтийг эсэргүүцэх чадвартай
- Олон төрлийн химийн бодист тэсвэртэй
- Олон төрлийн бэрхшээлтэй нөхцөл байдалд хэрэглэхэд тохиромжтой олон талт систем юм.

Зөвшөөрөл / Стандарт

Эрүүл Ахуйн Институт: Байгаль орчны Засгийн Газрын Агентлагын (UBA) KTW- Удирдамжийн дагуу, Ундны усанд хэрэглэхэд нийцсэн, тестийн дүгнэлт № K-178989-09, 2009 оны 7-р сар

CEN/TS 14416 –ийн дагуу хөрсний үндэс нэвчилтийг эсэргүүцэх чадварын үнэлгээ хийлгэсэн болно.

Бүтээгдэхүүний үзүүлэлт

Хэлбэр / Төлөв

Харагдах байдал / Өнгө

Sikadur-Combiflex® SG-10/-20 P Тууз:
Уян хатан, цайвар саарал өнгийн мембран

Sikadur-Combiflex® SG-10/-20 M Тууз:
Уян хатан, өргөтгөлийн заагт гүйцэтгэх ажлыг хялбарчилах зорилготой улаан мааскан туузтай цайвар саарал өнгийн мембран

Sikadur-Combiflex® CF болон *Sikadur® -31 CF* цавуу:
Цайвар саарал өнгөтэй

Sikadur® -31 DW:
Саарал өнгөтэй

Сав баглаа боодол

Sikadur-Combiflex® SG system cem боодол:
Cem савлагааны бүрдэлд:
Sikadur-Combiflex® CF энгийн төрлийн цавуу – 6 кг
Sikadur-Combiflex® SG -10 M 150 (15 см өргөн, 1 мм зузаан) – 6 м
Sika Colma Cleaner (багаж цэвэрлэгч бодис) – 1 кг

Sikadur-Combiflex® CF болон *Sikadur® -31 CF* цавуу:
6 кг хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн (А+Б хэсэг)
20 кг А хэсэг
10 кг Б хэсэг

Sikadur® -31 DW цавуу:
6 кг хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн (А+Б хэсэг)
30 кг А хэсэг
10 кг Б хэсэг

Sikadur-Combiflex® SG-10 P:
Зузаан: 1 мм
Өргөн: 10, 15, 20, 25, 30, 40, 50, 100, 200 см
Ороомогтоо 25 м-тэй

Sikadur-Combiflex® SG-20 P:
Зузаан: 2 мм
Өргөн: 15, 20, 25, 30, 40, 50, 100, 200 см
Ороомогтоо 25 м-тэй

Sikadur-Combiflex® SG-10 M :
Улаан маскан туузтай
Зузаан: 1 мм
Өргөн: 10, 15, 20, 25, 30 см

Ороомогтоо 25 м-тэй

Sikadur-Combiflex® SG-20 M :

Улаан маскан туузтай

Зузаан: 2 мм

Өргөн: 15, 20, 25, 30 см

Ороомогтоо 25 м-тэй

Хадгалалт

Хадгалах нөхцөл / Хугацаа

Sikadur-Combiflex® CF, Sikadur® -31 CF болон Sikadur® -31 DW
цавуунууд:

Сав баглаа боодол онгойж, гэмтээгээгүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 24 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд +5°C+30°C орчинд хадгална.

Sikadur-Combiflex® SG -10/-20 P Тууз:

Сав баглаа боодол онгойж, гэмтээгээгүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 36 сарын хугацаанд хуурай сэрүүн хадгална. Сав баглаа боодлыг задалсанаас хойш 2 сарын дотор туузан мембраныг хэрэглэх шаардлагатай.

Sikadur-Combiflex® SG -10/-20 M Тууз:

Сав баглаа боодол онгойж, гэмтээгээгүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 12 сарын хугацаанд хуурай сэрүүн хадгална. Сав баглаа боодлыг задалсанаас хойш 2 сарын дотор туузан мембраныг хэрэглэх шаардлагатай.

Техникийн үзүүлэлт

Химийн найрлага

Sikadur-Combiflex® CF, Sikadur® -31 CF болон Sikadur® -31 DW
цавуунууд:

Уусгагч агуулаагүй, сайжруулсан 2 бүрэлдэхүүнт эпокси цавуугаас бүрдсэн

Sikadur-Combiflex® SG Тууз:

Барьцалт сайтай, сайжруулсан уян полиолефин (FPO)

Ашиглалтын температур

Sikadur-Combiflex® SG System:

Чийгтэй орчинд хамгийн багадаа -30°C / хамгийн ихдээ +40°C

Хуурай орчинд хамгийн багадаа -30°C / хамгийн ихдээ +60°C орчинд

Механик / Физик шинж чанар

Барьцалтын бат бэх

Sikadur-Combiflex® SG System (Sikadur-Combiflex® CF цавуугаар
цавуудсан Sikadur-Combiflex® SG тууз):

ГАДАРГУУ	БАРЬЦАЛТЫН БАТ БЭХ
Бетон (хуурай)	> 2 кг/см ² (бетоны гэмтэл)
Бетон (чийглэсэн)	> 2 кг/см ² (бетоны гэмтэл)
Ган төмөр (үлээгчээр цэвэрлэсэн)	> 5 кг/см ²

Хуулах бат бэх

Sikadur-Combiflex® SG System:

Sika Системийн тест: Sikadur-Combiflex® SG туузыг хоорондоо нь Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF болон Sikadur®-31 DW зэрэг цавуунуудаар барьцалдуулна.

Үр дүн: Бат бэх > 6 N/mm (2 мм)
Бат бэх > 4 N/mm (1 мм)

Эсэргүүцэл

Химийн эсэргүүцэл

Sikadur-Combiflex® SG System (Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF болон Sikadur®-31 DW зэрэг цавуугаар наасан Sikadur-Combiflex® SG тууз)

Урт хугацаанд:

Ус, шохойн ус, цементтэй ус, далайн ус, давст уусмал, ахуйн хэрэглээний бохир, битум (EN 1548 дагуу), битум суурьтай эмульсэн түрхлэгүүд (будгийн бодис) г.м.

Богино хугацаанд:

Шингэн түлшний тос, дизель тос, шингэрүүлсэн шүлт болон минерал хүчлүүд, этанол, метанол, бензин г.м.

Химийн эсэргүүцлийн дээрх заалтаар битүүлэх системийн тохиромжтой эсэхийг тодорхойлоход хэрэглэгдэж болно. Богино хугацааны химийн эсэргүүцлийн талаарх тодорхой мэдээллийг манай Техникийн хэлтэстэй холбогдон авах боломжтой.

Системийн мэдээлэл

Системийн бүтэц



Sikadur-Combiflex® SG System –ийн бүрэлдэхүүнд сайжруулсан уян полиолефин (FPO) усанд тэсвэртэй тууз болон Sikadur® нэрийн эпокси цавуу багтана.

2 төрлийн уян туузнаас сонголтоо хийх боломжтой:

- Sikadur-Combiflex® SG -10/-20 M:

Өргөтгөлийн заагт хэрэглэгдэх улаан мааскан туузтай мембран

- Sikadur-Combiflex® SG -10/-20 P:

Улаан мааскан туузгүй мембран

Дараах төрлийн цавууны сонголттой:

- Sikadur®-Combiflex® CF цавуу (N, R төрөл)

- Sikadur® -31 CF (N, R, S төрөл)

- Sikadur® -31 DW (ихэвчлэн ундны устай хүрэлцэж буй орчинд хэрэглэдэг)

Санамж: системийн бүтцийг тодорхойлогдсоны дагуу бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд ямар нэгэн өөрчлөгдөх зүйл байхгүй.

Хэрэглэх заавар

Зарцуулалт

Sikadur-Combiflex® SG Тууз:
Sikadur-Combiflex® CF цавуу 1 метр тутмын уртад

Туузны өргөн	Туузны зузаан	Цавууны зарцуулалт *
10 см	1 мм	~ 0.7 кг/м
15 см	1 мм	~ 1.0 кг/м
20 см	1 мм	~ 1.2 кг/м
15 см	2 мм	~ 1.1 кг/м
20 см	2 мм	~ 1.4 кг/м
25 см	2 мм	~ 1.7 кг/м
30 см	2 мм	~ 2.0 кг/м

* Талбайн нөхцөл байдлаас (гадаргуун тэгш бус байдал, дүүргэгчийн хэмжээ г.м) шалтгаалан бодит зарцуулалтын хэмжээ өөр гарах магадлалтай.

Гадаргуун чанар

Бетон, чулуу, шавардлага, өнгөлгөөний шавардлага:

Гадаргуу нь сул эд хэсэггүй бат бэх байж, тос тосоол, тоос шороо болон бусад бохирдлоор ангид, цэвэр байх шаардлагатай. Орчны нөхцөл байдлаас шалтгаалан бетон нь 3-6 долоо хоногийн настай байх шаардлагатай.

Барилгын ган төмөр 37, V2A-ган төмөр (WN 1.4301):

Тос тосоол, зэв, шохойноос ангид, цэвэр байх шаардлагатай.

Полиэфир, эпокси, шаазан, шил:

Тос тосоолоос ангид, цэвэр байх шаардлагатай.

Гадаргууг бэлдэх

Бетон, чулуу, шавардлага, өнгөлгөөний шавардлага:

Механик аргаар гадаргуу дээрх гэмтэлтэй сул хэсгийг хуулан авч, урвалд орж болзошгүй түрхлэг, арчилгааны бүтээгдэхүүнүүд болон цементийн сүүг цэвэрлэж, цахилгаан үлээгчээр сайтар үлээлгэж өгнө.

Барилгын ган төмөр 37:

Цахилгаан үлээгч болон түүнтэй ижил тоос соруулагч тоног төхөөрөмжөөр гадаргууг сайтар цэвэрлэнэ. Гүйцэтгэлийн үед шүүдрийн цэг үүсэхээс сэргийл.

V2A-ган төмөр (WN 1.4301):

Зөөлөн зүлгүүрээр гадаргууг зүлгүүрдээд дараа нь тоос соруулагчаар сайтар цэвэрлэнэ. Гүйцэтгэлийн үед шүүдрийн цэг үүсэхээс сэргийл.

Полиэфир, эпокси, шаазан, шил:

Гадаргууг арзайлгагч зөөлөн зүлгүүрээр зүлгүүрдээд дараа нь тоос соруулагчаар сайтар цэвэрлэнэ. Силиконжсон болон силиконы тосоор боловсруулсан гадаргуу дээр хэрэглэж болохгүй (хуульраhad нөлөөлөх бодис). Гүйцэтгэлийн үед шүүдрийн цэг үүсэхээс сэргийл.

Хэрэглэх нөхцөлүүд /

Хязгаарлалтууд

Гадаргуун температур

Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF цавууны хувьд:

Төрөл-Удаан (S) +25°C +45°C орчинд
Төрөл-Хурдан (R) +5°C +15°C орчинд
Төрөл-Энгийн(N) +10°C +30°C орчинд

Sikadur®-31 DW цавууны хувьд: +10°C +30°C орчинд

Орчны температур	<i>Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF цавууны хувьд:</i>	
	Төрөл-Удаан (S)	+25°C +45°C орчинд
	Төрөл-Хурдан (R)	+5°C +15°C орчинд
	Төрөл- Энгийн(N)	+10°C +30°C орчинд
	<i>Sikadur®-31 DW цавууны хувьд:</i> +10°C +30°C орчинд	

Гадаргуун чийгшилийн Хэмжээ	<i>Цементэн суурьтай гадаргуунд:</i> Хуурай, өнгөцхөн чийгтэй байх Өнгөц чийгтэй гадаргуу дээр хэрэглэхдээ цавууг багсаар сайтар багсдаж өгөх хэрэгтэй.
------------------------------------	---

Харьцангуй чийгшлийн Хэмжээ	+25°C орчинд хамгийн ихдээ 85%
------------------------------------	--------------------------------

Шүүдрийн цэг	Конденсаци үүсэхээс сэргийл. Гадаргуу нь хамгийн багадаа шүүдрийн цэгээс дээс +3°C байх шаардлагатай.
---------------------	--

Хэрэглэх заавар

Холих *Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF цавууны хувьд:*
Жин болон эзлэхүүний хувьд А хэсэг : Б хэсэг = 2 : 1 харьцаатай байна

Sikadur®-31 DW цавууны хувьд:
Жин болон эзлэхүүний хувьд А хэсэг : Б хэсэг = 3 : 1 харьцаатай байна

Сет болгон урьдчилан савлагдсан бүтээгдэхүүн:



А болон Б хэсгийг хооронд холиод, саарал өнгийн нэгэн жигд зуурмаг болтол бүтээгдэхүүнийг ээрүүл хэлбэртэй хошуутай, бага хурдтай (хамгийн ихдээ минутанд 300 эргэлттэй) цахилгаан холигчоор хамгийн багадаа 3 минутын турш хольж өгнө. Холих явцад агаарыг бөмбөлөг үүсэхээс сэргийл. Үүний дараа хольцыг цэвэр хувин руу бүгдийг юулэн хийгээд дахин 1 минутын турш бага хурдаар хольж агаарын бөмбөлөгийг бууруулж өгнө. Нээлттэй байж хугацаанд ашиглах хэмжээний цавууг л холих хэрэгтэй.

Их хэмжээгээр савлагдсан (сет бүтээгдэхүүн биш) бүтээгдэхүүн:



Эхлээд А болон Б хэсгийг тус тусад нь сайтар хольж өг. Тохиромжтой саванд тооцоолсон харьцааны дагуу А болон Б хэсгийг хийгээд бага хурдтай цахилгаан холигчоор сетээр савлагдсан цавууг холих аргачлалын дагуу зөв холих хэрэгтэй.

Хэрэглэх заавар / Багаж

Туузны хэмжээний сонголт:

Тооцоолж буй үзүүлэлтээс хамааран туузны хэмжээ (өргөн ба зузаан) болон тохиромжит Sika® цавууны сонголтыг хийнэ. Шаардлагатай тохиолдолд манай Техникийн хэлтэстэй холбогдон техникийн мэдээллийг авч болно. 1 мм-ийн зузаантай тууз нь зөвхөн хөнгөн ачаалал бүхий залгаасыг битүүлэхэд тохиромжтой.

Урт хугацаанд зөвшөөрөгдөх суналтын хамгийн их хэмжээ:

1 мм-ийн тууз: Цавуулаггүй туузын өргөний 10%


2 мм-ийн тууз: Цавуулаггүй туузын өргөний 25%

Анхаар: Хөдөлгөөний ачаалал ихтэй орчинд гүйцэтгэлийг хийхдээ залгаасны зангилаан дээр туузыг суурилуулан тогтоох хэрэгтэй.

Туузны гүйцэтгэл:

Sikadur®-Combiflex® SG Туузан дээрх бохирдлыг хуурай болон чийгтэй цэвэр даавуугаар арчина. Ийм цэвэрлэгээнд ямар нэгэн уусгагч ашиглаж болохгүй бөгөөд зөвхөн усаар л цэвэрлэх ёстой. Sikadur®-Combiflex® SG тууз нь бүрэн бүтэн эсэх, тээвэрлэлт, хадгалалтын үед ямар нэгэн гэмтэл үүссэн эсэхийг (том хэмжээний урагдалт г.м) шалга. Шаардлагатай тохиолдолд гэмтэлтэй хэсгийг хэсэгчлэн тайрч ав.

Анхаар: Төслийн талбай дээр ямар нэгэн идэвхжүүлэгч хэрэглэх шаардлагагүй.



1 мм-ээс их хагаралтай болон өргөтгөлийн залгаанд хэрэглэх тохиолдолд туузны төв хэсгийг гадаргуу болон заалгаас дүүргэгчтэй барьцалдуулан наалж болохгүй. Энэ тохиолдолд цаасан туузыг хагарал болон залгаасны төв хэсэг дээр болон залгаасны 2 гадна талаар нааж өг.



Урьдчилан хольсон Sikadur® цавуугаа залгаас/хагаралын 2 талын бэлтгэгдсэн гадаргуу дээр багс, нийвий, хусуурын аль тохиромжтойгоор нь түрхэж өгнө. Хэрэв бетоны гадаргуу чийгтэй байвал цавууг гадаргуутай сайтар барьцалдуулах зорилгоор сайтар дарж өгнө. Залгаас/хагарлын 2 талаар түрхэх цавууны зузаан нь 1-2 мм ба өргөн нь хамгийн багадаа 40 мм байна.



Combiflex туузаа наахаас өмнө хагарал болон өргөтгөлийн залгаасын гадаргуун төвд наасан цаасан туузыг авч хая.



Combiflex SG туузаа цавууны нээлттэй байх хугацаанд багтан нааж өг. Туузаа цавуун дээр тохирох өнхрүүшээр жигд дарж, ямар нэгэн агаар үүсгэлгүй барьцалдуулж өгөх хэрэгтэй. Ингэснээр залгаасны 2 талаар цавуу нь ойролцоогоор 5 мм шахагдах гарч ирэх ёстой.

1 мм-ээс их хагаралд болон өргөтгөлийн залгаасанд Sikadur®-Combiflex® SG -10/-20 M туузыг хэрэглэх бөгөөд улаан мааскан туузыг дээш нь харуулан наах хэрэгтэй.

Хөдөлгөөний ачаалал ихтэй орчинд гүйцэтгэлийг хийхдээ залгаасны зангилаан дээр туузыг суурилуулан тогтоох хэрэгтэй.




Таазны болон саад ихтэй орчинд гүйцэтгэлийг хийхдээ Sika® Trocal Adhesive C-705 цавуугаар туузыг түр зуур бэхлэн тогтоож болно. Гэхдээ энэ цавууг зөвхөн туузны төв хэсэгт түрхэж өгөх буюу Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF болон Sikadur®-31 DW цавууг түрхэх талбайд огтхон ч түрхэж болохгүй.

Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF болон Sikadur®-31 DW цавууны эхний үе хатуурч бэхэжсэний дараа, хагарал/залгаасны 2 талаар бүхэлд нь дараагийн үе давхрага цавууг ойролцоогоор 1 мм-ийн зузаантай түрхэнэ.



Голын улаан тууз болон залгаасны гадна талын 2 цаасан туузыг хуулан авсанаар гүйцэтгэлийн ажил цэвэр нямбай харагдана.



шингэлсэн савантай усанд дүрсэн багсаар 2 дахь үе давхрагын цавууг тэгшилж толийлгож болно. Гэхдээ үүнийг цавууны өнгөн хэсэг бэхжиж эхэлсэний дараа хийж өгөх хэрэгтэй.

Анхаар: Цавууны үе давхар хооронд шингэрүүлсэн савантай усыг түрхэж болохгүй.

1 мм-ээс их барилгын залгаас болон хагарлыг битүүмжлэхдээ туузыг бүхэлд нь Sikadur®-Combiflex® CF, Sikadur®-31 CF болон Sikadur®-31 DW цавуугаар түрхэж болох бөгөөд ингэснээр механик хамгаалалтыг давхар үүсгэнэ. Энэ тохиолдолд Sikadur®-Combiflex® SG туузны голд байрлах улаан мааскан туузыг доош нь харуулан нааж өгнө.

Sikadur®-Combiflex® SG туузыг холбох

Туузны үзүүрийг хооронд нь халуунаар үлээгч гагнуурын багажаар холбож өгнө. Гагнах хэсгийн гадаргууг цаасан зүлгүүрээр барзайлгаж өгөх шаардлагатай. Зөвхөн халуун үлээгч гагнуураар холбох хэсгийг гадаргууг л барзайлгах хэрэгтэй, барзайлттай гадаргуу нь цавууны барьцалтад сөргөөр нөлөөлөх боломжтой.



Давуулан хучих хэмжээ нь 40-50 мм-ийн хэмжээтэй байх шаардлагатай.

Халуун үлээгч гагнуурын хурд, температурын зохимжит үзүүлэлтийг төслийн талбай дээр туршиж үзээд тодорхойлно.

Эхлэл тохиргоо нь: 360-420°C байна.

Давуулан хучиж холбох орчинд гар гагнуурын ажиллагаа нь дараах 3 шат дараалалтай байна.

1. Давуулан хучих хэсгийг товчилж гагнах
2. Урьдчилж гагнах: давуулан хучих хэсгийн зөвхөн нуруу хэсгийг гагнаж үзүүр хэсэгт ойролцоогоор 20 мм хэсгийг (20мм-ийн гагнуурын хошуу хэрэглэнэ) төгсгөл гагнаасын ажиллагаанд үлдээнэ.
3. Үлдсэн хэсгийг гагнах. Гагнуурын хошуураас үлээх агаарын зүг рүү 20 мм-ийн зайнд даралтад өнхрүүшээр гагнасан талбай дээгүүр параллелиэр сайтар дарж өгнө. Даралтад өнхрүүхээр гагнаасын заадлыг давуулан дарж өгөх хэрэгтэй.

Анхаар: Sika Colma Cleaner зэрэг уусгагч нь гагнуурын шинж чанарт эерэгээр нөлөөлөхгүй.

Sikadur®-Combiflex® SG туузыг Sika® AR төрлийн гадна талын усны PVC хаалттай холбох (зөвхөн барилгын залгаанд зориулсан):

AR төрлийн усны хаалтыг Sikadur®-Combiflex® SG туузаар давуулан хучихдаа хамгийн багадаа туузны өргөний хэмжээтэй давуулж өгнө.

Sikadur®-Combiflex® SG туузаа хуурай, цэвэр алчуураар арч. Усны хаалтаа Sika Colma Cleaner-ээр цэвэрлээд хатаана.

Sika® Primer 215 суурь түрхлэгийг усны хаалтанд түрх (Sika® Primer 215-ийн бүтээгдэхүүний техникийн зааварчилгааны хуудастай танилцана уу).

SikaFlex® 11FC+ битүүмжлэгч цавууг ойролцоогоор 1 – 3 мм-ийн хэмжээтэй түрхэж Sikadur®-Combiflex® SG туузыг Sika® Усны хаалтыг хооронд нь нааж өгнө.

Хүрэлцэж байгаа талбайд SikaFlex® 11FC+ цавууг хусуураар түрхэж хучих хэрэгтэй.

Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө Sika® Colma Cleaner цэвэрлэгчээр цэвэрлэх хэрэгтэй. Бэхжиж хатсан бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Нээлттэй байх хугацаа

Sikadur-Combiflex® CF цавуу (6 кг)		
Температур	Төрөл - Энгийн	Төрөл - Хурдан
+5° C	-	~ 60 минут
+10° C	~ 125 минут	~ 45 минут
+15° C	~ 95 минут	~ 25 минут
+23° C	~ 50 минут	-
+30° C	~ 25 минут	-

Sikadur®-31 CF цавуу (0.2 кг)			
Температур	Төрөл - Удаан	Төрөл - Энгийн	Төрөл - Хурдан
+5° C	-	-	~ 60 минут
+10° C	-	~ 145 минут	~ 55 минут
+23° C	~ 135 минут	~ 55 минут	~ 40 минут
+30° C	-	~ 35 минут	-
+35° C	~ 70 минут	-	-
+45° C	~ 45 минут	-	-

Температур	Sikadur®-31 DW цавуу (0.2 кг)
+23° C	~ 90 минут

Цавууг их хэмжээтэйгээр хольсон тохиолдолд химийн урвалын нөлөөнөөс үүдэн цавууны температур өсөх бөгөөд үүний үр дүнд нээлттэй байх хугацаа богиносгох болно.

Хүлээх / давхарлах будгах хугацаа

Sikadur®-Combiflex® CF, Sikadur® -31 CF болон Sikadur® -31 DW зэрэг цавуун дээр эпокси суурьтай түрхлэгээр давхарлан будах боломжтой. Энэ тохиолдолд цавууны гадаргууг шингэрүүлсэн савантай уусмалаар тэгшилж болохгүй. Хэрэв цавууг түрхсэний дараа давхарлага түрхлэгийн гүйцэтгэлийг 2-оос дээш хоногийн дараа хийгдэх тохиолдолд цавууг түрхсэний дараа түүнийг кварцын элсээр хучиж өгөх хэрэгтэй.

Анхаарах зүйлс / Боломжууд

Гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүтээгдэхүүний Хэрэглээний Аргачлалаас үзнэ үү.

Хэрэв устай хүрэлцэх орчинд залгаасыг Sikadur®-Combiflex® SG System-ээр битүүмжлэх тохиолдолд залгаасан дээр туузыг тогтоож өгөх хэрэгтэй. Үүнд хатуу хөөсөнцөр болон заадасны чигжээсийг ашиглахыг зөвлөж байна.

Хэрэв усны даралт ихтэй орчинд Sikadur®-Combiflex® SG System-ийг хэрэглэх тохиолдолд залгаасыг төмөр хавтан хаалтаар хааж туузыг хамгаалах хэрэгтэй.
Хамгаалалтгүй хийгдэх хязгаар: хамгийн ихдээ 5 баарын хүчтэй усны даралттай, 20 мм-ийн заадастай, +20°С орчинд 2мм-ийн зузаантай туузан наалтыг суурилуулах боломжтой.

Хэрэв Sikadur®-Combiflex® SG туузны гадна талаар битум түрхлэг хийх тохиолдолд түрхлэгийн халуун +180°С –ээс хэтрээгүй, 50 мм-ийн зузаанаас илүүгүй хийгдэх ёстой. 10 мм-ийн зузаантай хийгдэх тохиолдолд халуун түрхлэгийн температур +220°С байх боломжтой.

Шаардлагатай тохиолдолд үе давхар болгон давхарлан түрхэх ба үе давхар хооронд гадаргууг хөргөөж өгөх хэрэгтэй.

Sikadur®-Combiflex® SG туузыг механик гэмтэлээс хамгаал.

Sikadur®-Combiflex® SG тууз нь халуун үлээгч гагнуураар гүйцэтгэгддэг SikaPlan WT болон Хиралон суурьтай (Huralon, жишээ нь хуучны Sikadur-Combiflex) мембрантай нийлүүлж болохгүй.

Дүгнэлт Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Эрүүл ахуй, аюулгүй Ажиллагааны мэдээлэл Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хууль эрх зүйн мэдээлэл Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika Services AG
Tueffenwies 16
CH-8048 Zurich
Switzerland

Phone: +41 44 436 40 40
Telefax: +41 44 436 46 86
www.sika.com

